/

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2021 оны 10 сарын 20 өдөр Дугаар 113 Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10,000,000 /арван сая/ төгрөгийн балансын үнэтэй, 1,666,667 /нэг сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 00-12 улсын дугаартай УАЗ пургон маркийн автомашиныг нэгдүгээр хавсралтаар, 5,209,956.60 /таван сая хоёр зуун есөн мянга есөн зуун тавин зургаан төгрөг жаран мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 2,095,441.04 (хоёр сая ерэн таван мянга дөрвөн зуун дөчин нэгэн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 14 нэр төрлийн 19 ширхэг эд хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр.Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын дарга (Д.Доржсүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг актлах, автомашины акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, ;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОДЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн 113 тогтоолын нэгдүгээр хавсралт

Төв халхын дуулалт жүжгийн театрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн он | Ашиглалтад орсон огноо | Тээврийн хэрэгслийн | | | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сери | Дугаар | | | Арлын дугаар | Моторын дугаар | Моторын ээлэхүүн /см3/ | | | | |
| 1 | Суудал | УАЗ пургон | ДУА | 00-12 | 2009 | 2009.12.30 | 4037765 | 90003563 | 2890.D | 99260 | 10 000 000 | 8 333 333 | 1 666 667 |

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн .113. тогтоолын хоёрдугаар хавсралт

ТХДЖТеатрын актлах хөрөнгийн мэдээлэл

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | х/нэгж | Тоо/ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Данснаас хасах болсон шалтгаан | Актлах төрөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Kenwood станц | 2014.06.26 | ш | 6 | 129746,10 | 778476,60 | 778476,60 | 337340.64 | 441135.96 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 2 | Явуулын өсгөгч микропон | 2018.06.30 | ш | 1 | 440000 | 440000 | 440000 | 263999.88 | 176000.12 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 3 | Лазер | 2018.06.30 | ш | 1 | 160500 | 160500 | 160500 | 96300 | 64200 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 4 | Хэрээс оёдлын машин | 2018.06.30 | ш | 1 | 40000 | 40000 | 40000 | 24000.12 | 15999.88 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 5 | Электрон пульт | 2018.06.30 | ш | 1 | 150000 | 150000 | 150000 | 90000 | 60000 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Шкаф,түмбүчикний ком | 2011.07.01 | ш | 1 | 696000 | 696000 | 696000 | 632000 | 64000 | эвдэрсэн | |
| 7 | Гэрлийн пульт | 2018.06.30 | ш | 1 | 150000 | 150000 | 150000 | 131250 | 18750 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 8 | Принтер SCX-4300 | 2018.06.30 | ш | 1 | 450880 | 450880 | 450880 | 270528.12 | 180351.88 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 9 | Бандан сандал | 2018.06.30 | ш | 1 | 366300 | 366300 | 366300 | 219780 | 146520 | Ашиглах боломжгүй болсон | Устгах |
| 10 | Том ятга | 2018.06.30 | ш | 1 | 180900 | 180900 | 180900 | 150750 | 30150 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 11 | Ерөнхий шар хөшиг | 2018.12.31 | | 1 | 300000 | 300000 | 300000 | 262500 | 37500 | Ашиглах боломжгүй болсон | Устгах |
| 12 | Ямаха хөгжим | 2018.06.30 | ш | 1 | 1200000 | 1200000 | 1200000 | 360000 | 840000 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| 13 | Компьютерийн дэлгэц | 2013.03.26 | ш | 1 | 141900 | 141900 | 141900 | 141900 | 0 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Компьютерийн дэлгэц | 2018.12.31 | ш | 1 | 155000 | 155000 | 155000 | 129166.80 | 20833.20 | Эвдэрсэн засварлах боломжгүй | Устгах |
| | **Дүн** | | | | | | **5,209,956.60 (таван сая хоёр зуун есөн мянга есөн зуун тавин зургаан төгрөг жаран мөнгө)** | | **2,095,441.04 (хоёр сая ерэн таван мянга дөрвөн зуун дөчин нэгэн төгрөг дөрвөн мөнгө)** | | |